



Г АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН  
ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН  
ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020 02.18 № 05/2075


танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Ашигт малтмал, газрын тосны газрын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ, зах зээл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Гылымханы Жандаулетын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, 33.3-т заасны дагуу төрийн албаны тусгай шалгалт буюу албан тушаалын шалгалт өгч зохих журмын дагуу нэр дэвшүүлснээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох эрх зүйн зохицуулалттай байх бөгөөд нэр дэвшигч Г.Жандаулет нь төрийн албаны ерөнхий шалгалт өгч, нөөцөд бүртгэгдсэн хэдий ч нэр дэвшиж буй албан тушаалын тусгай шалгалт өгөөгүй байх тул түүнийг тухайн албан тушаалд түр болон жинхэнэ томилох эсэх талаар Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг авч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР *Дамжин* Х.ХАШБААТАР



0002872